

СУДЛААЧ ШАЛГАРУУЛНА

“Орон нутагт эмнэлгийн мэргэжилтнийг тогтвортой ажиллуулах бодлогод шинжилгээ хийх, бодлогын загвар боловсруулах” ажил гүйцэтгэх судлаач шалгаруулж байна. Судалгааны хамрах хүрээ:

1. Монгол улсад орон нутагт эмнэлгийн мэргэжилтнийг тогтвортой ажиллуулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааг тоймлон үнэлж, энэ чиглэлээр ДЭМБ-с зөвлөмж болгосон 16 зөвлөмжтэй харьцуулан дүн шинжилгээ хийх;
2. Авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааг үр дүнгээр эрэмблэх шалгуур боловсруулан, тэдгээрийн дагуу хамгийн чухал ач холбогдол бүхий 3 үйл ажиллагааг сонгон, бодлогын зөвлөмж боловсруулах;

Судлаач нь дараахь шаардлагыг хангасан байна:

1. Эрүүл мэндийн бодлого, тогтолцооны судалгаа шинжилгээний талаар зохих туршлагатай байх (бүтээлийн жагсаалтаар үнэлнэ)
2. Судалгааны мэдээлэл цуглуулах, боловсруулалт, дүн шинжилгээ хийх арга аргачлал эзэмшсэн байх

Уг судалгааг гүйцэтгэхэд оролцох хүсэлтэй судлаач өөрийн дэлгэрэнгүй намтраа **2012 оны 2 сарын 10-ны 17 цагт** багтаан Эрүүл мэндийн яамны 311 тоот өрөөнд (мэргэжилтэн С.Гантуяа) ирүүлнэ үү. Хүсэлт ирүүлсэн судлаачдаас сонгон ярилцлага авах бөгөөд зөвхөн ярилцлага авахаар сонгогдсон судлаачтай холбоо барих болно.

Лавлах утас: (51) 263820 С. Гантуяа, С.Эвлэгсүрэн
Хаяг: Эрүүл мэндийн яам, 311 тоот өрөө
Засгийн газрын 8-р байр, Олимпийн гудамж 2,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот